

# БАЯНХОНГОР АЙМАГТ 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2021 оны 01 дүгээр сарын 06

Номгон

## 1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн талаар:

Тус цагдаагийн газар нь 2020 онд иргэд, аж ахуйн нэгжээс 4844 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 548 нэгжээр буюу 12,7 хувиар өссөн байна.



986 буюу 20,3%



3858 буюу 79,6%

- ✓ 505 буюу 51,2 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
- ✓ 441 буюу 44,7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан.


- ✓ 2750 буюу 71.2 хувийг Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн
- ✓ 1028 буюу 26.6 хувийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзсан
- ✓ 52 буюу 1.3 Харьяаллын дагуу шилжүүлсэн
- ✓ 1 буюу 0.02 хувийг ердийн журмаар шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 297 буюу 30,1 хувийг 5 хоногт, 649 буюу 65,8 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 3718 буюу 96,3 хувийг 5 хоногт, 113 буюу 2.9 хувийг 6 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

## 2. Бүртгэгдсэн гэмт хэрэг:


Аймгийн хэмжээнд энэ онд 462 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 180 нэгжээр буюу 28 хувиар буурсан.

Баянхонгор аймаг нь гэмт хэргийн гаралтаараа хил залгаа Говь-Алтай, Завхан, Архангай аймгаас 5,8-67,3 хувиар их бол Өвөрхангай аймгаас 16,2 хувиар бага байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийн 211 буюу 45,6 хувь нь Баянхонгор суманд, 251 буюу 54,3 хувь нь бусад суманд үйлдэгдсэн ба Баянхонгор суманд үйлдэгдсэн хэрэг 44,3 хувиар, бусад сумдад үйлдэгдсэн хэрэг 4,5 хувиар тус тус буурсан.

### Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




### Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 305 хэрэг бүртгэгдсэнээс 176 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 57,7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4,3 пунктээр өссөн байна.

#### Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 362 буюу 78,3 хувь нь хөнгөн ангиллын, 100 буюу 21,6 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг бүртгэгдсэн.




**2020 оны байдлаар /өссөн дүнгээр/**

Хэргийн ангилал	2019 он	2020 он	Харьцуулалт	
Хүнийг алах	7	2	-5	-71,4%
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	6	4	-2	-33,3%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	188	143	-45	-23,9%
Хүчиндэх	22	22		
Хулгайлах	165	80	-85	-51,5%
Тээврийн хэрэгслийн хулгай	9	2	-7	-77,7
Мал хулгайлах	101	66	-35	-34,6%
Дээрэм	1	1		
<b>Залилах</b>	<b>26</b>	<b>28</b>	<b>2</b>	<b>7,7%</b>
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	1	1		
<b>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг</b>	<b>24</b>	<b>25</b>	<b>1</b>	<b>4,1%</b>
<b>Хүрээлэн буй орчны эсрэг</b>	<b>20</b>	<b>53</b>	<b>33</b>	<b>1,6 дахин</b>
Бусад	81	36	-45	-54,8%


**Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа:**

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 462 гэмт хэргээс 131 буюу 28,3 хувь нь гэр орон сууцанд, 37 буюу 8 хувь нь гудамж талбайд, 35 буюу 7,5 хувь нь олон нийтийн газар, 3 буюу 0,6 хувь нь төрийн байгууллагад, 5 буюу 1 хувь нь төрийн бус байгууллагад, 24 буюу 5,2 хувь нь авто замд, 10 буюу 2,1 хувь нь аж ахуйн нэгжид, 217 буюу 46,9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:



Үйлдэгдсэн цаг:




**Гэмт хэрэгт холбогдсон хүн:**

Энэ хугацаанд нийт 400 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 нэгжээр буюу 9,2 хувиар буурсан бөгөөд үүнээс 37 буюу 9,2 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.

**Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:**

Гэмт хэргийн улмаас 476 иргэн хохирч, үүнээс 171 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 27 нэгжээр буюу 13,6 хувиар, 14 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14 нэгжээр буюу 100 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 1168,0 сая төгрөгийн хохирол учирснаас 610,3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 52,2 хувьтай байна.



### Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймагт 2020 онд 26421 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2931 нэгжээр буюу 10 хувиар буурсан. Ердийн журмаар /бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр/ 23562 зөрчлийг 472817.8 мянган төгрөгөөр, 2213 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 431000.0 мянган төгрөгөөр тус тус торгож, нийт 903817.8 мянган төгрөгийн торгууль ногдуулан ажилласан байна.

466 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 71 нэгжээр буюу 18 хувиар өссөн, 688 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 73 нэгжээр буюу 10.6 хувиар буурсан байна. Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:



Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	6496 буюу %	Даваа гараг	4025 буюу 15.2%
		Мягмар гараг	4220 буюу 15.9%
13-18 цагт	11945 буюу 45.4%	Лхагва гараг	4366 буюу 16.5%
		Пүрэв гараг	4197 буюу 15.9%
19-24 цагт	7227 буюу 27.2%	Баасан гараг	3712 буюу 14%
		Бямба гараг	3053 буюу 11.6%
01-05 цагт	753 буюу 2.7%	Ням гараг	2848 буюу 10.8%

Зөрчил үйлдэгдсэн байдлыг онцлогоор нь авч үзвэл:

Зөрчил үйлдэгдсэн онцлог	2019.12 сар	2020.12 сар	Харьцуулалт	
			Тоогоор	Хувиар
Согтуугаар	1529	1724	195	12.8%
Бүлэглэн	2	0	-2	-100%

Галт зэвсэг ашиглан	1	2	1	50%
Хүүхэд оролцсон	26	9	-17	-34.6%
Эмэгтэй хүн оролцсон	159	186	27	17%
Харьяалалгүй	-	2	2	100%
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	134	156	22	16.4%

Энэ хугацаанд 1048 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 192 нэгжээр буюу 15.5 хувиар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 40 буюу 3.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байна.

## ДҮГНЭЛТ

Баянхонгор аймагт 2020 онд 462 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 180 нэгжээр буюу 28 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 57,7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4,3 пунктээр өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 127 буюу 27,4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгжээр буюу 2,3 хувиар буурсан.

Хүнийг алах гэмт хэрэг 71,4 хувиар, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 33,3 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 23,9 хувиар, хулгайлах гэмт хэрэг 51,5 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 34,6 хувиар, бусад гэмт хэрэг 55,5 хувиар тус тус буурсан.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 4,1 хувиар, залилах гэмт хэрэг 7,7 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 1,6 дахин өссөн нь цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхээс гадна бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг тасралтгүй зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 44 хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 27 нэгжээр буюу 1,7 дахин, зөрчил 22 нэгжээр буюу 16,4 хувиар тус тус өссөн.

Баянхонгор сумын багуудад гэмт хэргийн гаралт 14,3-60,7 хувиар буурсан бол Баянбулаг, Баян-Өндөр, Бөмбөгөр, Бууцагаан, Жаргалант, Заг, Өлзийт, Шинэжинст, Эрдэнэцогт сумдад гэмт хэргийн гаралт 11,8-100 хувиар өссөн байна. Тэр дундаа Бөмбөгөр, Өлзийт, Баян-Овоо, Бууцагаан сумдад гэмт хэргийн гаралт өндөр байгаа нь анхаарал татахаар байна.

Энэ хугацаанд бүртгэгдсэн зөрчлийн шинжтэй 3858 гомдол мэдээллийн 1724 буюу 44,7 хувь нь согтуугаар үйлдэгдсэн зөрчил бүртгэгджээ. Нийт зөрчлийн илрүүлэлт 10 хувиар буурсан байна.

## САНАЛ

1. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр “Архигүй-Баянхонгор” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх,
2. Архины хамаарал /донтогч/ бүхий иргэдийг сайн дурын эмчилгээнд хамруулж, соён гэгээрүүлэх, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах,
3. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, орон нутгийн замд үйлдэгдэж байгаа зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын чанартай автозамд зорчиж байгаа тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тогтоох хяналтын камер /иж бүрэн/ байршуулах,
4. Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн холбоо” хяналтын бүлэг ажиллуулж, тэдний ур чадварыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж хамтран ажиллах,
5. Олон нийтийн цагдаа, олон нийтийн байцаагч, хүүхэд хамгаалагч, оюутан цагдаагийн орон тоо, хөршийн холбоо, малчдын бүлэг /холбоо/-ийг нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх сайн дурынхны үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Police volunteer” арга хэмжээг хэрэгжүүлэх,
6. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, газрын нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах,
7. Малын хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдын бүлгэмийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, улсын хэмжээнд зохион байгуулагдах “Мал мах” нэгдсэн арга хэмжээнд иргэд, олон нийтийг татан оролцуулах,
8. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж, энэ ажилд мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулах,

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.БЯМБАА

ТАНИЛЦСАН:

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.ОЮУТБОЛД